



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 20

Мандалговь

Г

7

Ч.Хүүхэнбаатарыг албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хулд сумын Санхүүгийн албаны даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Чойжилсүрэнгийн Хүүхэнбаатар 83.2 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Ч.Хүүхэнбаатарын санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанад даалгасугай.


ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



180051044

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын
15.-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт



**Хулд сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын
албан тушаалд нэр дэвшүүлсэн Чойжилсүрэнгийн Хүүхэнбаатарын
тухай дүгнэлт**

1. Ч.Хүүхэнбаатар нь 1981 онд Дундговь аймгийн Хулд сумын төвд төрсөн. 39 настай. Эмэгтэй.
2. Боловсролын байдал: Монгол улсын Их сургуулийн Эдийн засгийн сургуулийг 1997-2001 онд бизнесийн удирдлагын бакалавар зэрэгтэй суралцаж төгссөн. Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй.
3. Ажлын туршлага: 2010-2011 онд Хадгаламж банкны Дундговь аймаг дахь салбарт эдийн засагч, 2011-2014 онд Хулд сумын сургуулийн нягтлан бодогч, 2015-2019 онд Хулд сумын ЗДТГ-т нягтлан бодогч, 2019 оноос Хулд сумын сургуулийн нягтлан бодогчоор ажиллаж байна. Төрийн албаны шалгалтад 2018 онд орж тэнцэн нөөцөд бүртгэгдсэн.
4. Ч.Хүүхэнбаатарын төрийн албанад ажиллаж байгаа ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Хулд сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын албан тушаалд томилиулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ